

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТБОНӨБАҮХАТ хууль	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  
Ж.ЦОЛМОН ТАНАА

2020.03.13 № 06/845  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц.Наранчимэг*

Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Цолмон Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн авлагыг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ авах, худалдан авах ажиллагаандаа ТБОНӨБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийг мөрдөх болон цалин, хөлс, түүнтэй адилтгах орлогоос холбогдох хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар суутгах талаар 3 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль, стандарт болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 17-ноос 2020 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “СМД аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/250 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн, эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Номхон далайн баруун эргийн бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино” гэж тодорхойлсон байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажил эрхлэх, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг эрхлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”;

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Ординат” ХХК-ийн “Unicus” программ хангамж ашигладаг байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 23 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 28,128.3 сая төгрөгөөс тооцон 281.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал болох 35,324.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцож 353.2 сая төгрөгөөр тогтоов.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,564.9 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28,590.5	13,266.7	(15,323.8)
Авлага	4,439.7	14,142.8	9,703.1
Урьдчилгаа	301.6	10.5	(291.1)
Бараа материал	692.4	739.4	47.0
Үндсэн хөрөнгө	71,920.5	81,350.2	9,429.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>105,944.7</b>	<b>109,509.6</b>	<b>3,564.9</b>
Өр төлбөр	1,237.6	159.0	(1,078.6)
Урьдчилж орсон орлого	4,767.7	4,945.7	178.0
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>6,005.3</b>	<b>5,104.7</b>	<b>(900.6)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	99,939.4	104,404.9	4,465.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>105,944.7</b>	<b>109,509.6</b>	<b>3,564.9</b>

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данснуудад материаллаг өөрчлөлт гарсан. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 15,323.8 сая төгрөгөөр буурсан нь 4,087.3 сая төгрөгийн Капитал банканд байршуулсан хадгаламжийг авлагаар бүртгэсэн, дуусаагүй барилгыг 9,907.1 сая төгрөгөөр санхүүжүүлсэн, 1,078.5 сая төгрөгийн өглөг барагдуулсан зэргээс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл нь 9,703.1 сая төгрөгөөр өссөн нь Капитал банканд байршуулж байсан хадгаламж 4,087.3 сая төгрөгийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн, сургалтын төлбөрийн 7,032.3 сая төгрөгийн авлагатай байна. Эдгээр авлагаас сургалтын төлбөрийн авлага нь богино хугацаанд барагдах боломжтой авлага байна.

Байгууллагаас авах авлагад ойрын хугацаанд барагдах боломжгүй, эрсдэлтэй 4,205.2 сая төгрөгийн авлага байна. Үүнд, Капитал банкнаас авах 4,087.3 сая төгрөгийн авлага нь өмнөх дараалалд хамаарах 187,200.0 сая төгрөгийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар барагдуулах хуулийн зохицуулалттай байна. Шинэ цогцолборын А, Б блокийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн 2 компаниас авахаар 2018 онд үүсгэсэн 117.9 сая төгрөгийн авлагыг эдгээр компани хүлээн зөвшөөрөхгүй шүүхэд нэхэмжлэл гаргасан байгаа тул тайлант онд авлага барагдуулаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,429.8 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 56 тоот тогтоолоор батлагдсан 17,818.4 сая төгрөгийн төсөвт багтаан 12,871.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 444.8 сая төгрөгийн хөрөнгө хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ. Тайлант онд 3,886.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн байгуулжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,078.5 сая төгрөгөөр буурсан нь бараа, үйлчилгээний зардлын 161.7 сая төгрөгийн өглөг, байгууллагад өгөх 897.2 сая төгрөгийн өглөг, хувь хүмүүст өгөх 19.6 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 159.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд 7.0 сая төгрөг нь ажилчидтай холбоотой өглөг, 143.1 сая төгрөг нь байгууллагад төлөх өглөг, 8.7 сая төгрөг нь хувь хүнд төлөх өглөг байна. Байгууллагад өгөх өглөгт А, Б блокийн барилга угсралттай холбоотой 4 компанид өгөх нийт 59.6 сая төгрөгийн өглөгтэй байна. Эдгээр компани өглөгийн дүнг зөвшөөрөхгүй шүүхэд нэхэмжлэл гаргасан, тайлант онд төлөлт хийгээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 104,404.9 сая төгрөг болсон нь тайлант оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн 4,465.5 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

## **2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т заалтын дагуу, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 10 тоот тогтоолоор Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны төсвийг баталж, Удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 14 тоот тогтоолоор 2019 оны төсөвт тодотгол хийсэн байна.

Удирдах зөвлөлийн зорилтот түвшин баталсан шийдвэрээр, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь тайлант онд 37,085.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 32,124.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 86.6 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвөөс санхүүжих орлого 2,381.2 сая төгрөгөөр давсан нь Боловсролын зээлийн сангийн оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламж, Шинжлэх ухаан технологийн сангийн төсөл, Дээд боловсролын шинэчлэлийн төсөл зэргээс орсон санхүүжилтээс шалтгаалсан байна. Орон нутгийн төсвөөс санхүүжих орлого 30.0 сая төгрөгөөр давсан нь Говь-Алтай аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 30.0 сая төгрөгийн санхүүжилт авсан, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого 22.7 сая төгрөгөөр тасарсан нь эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт эдлэх эрхтэй сувилалд амрагчийн тоо буурсантай холбоотой байна.

Тайлант онд байгууллагын үйл ажиллагаанаас 35,055.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан ба аккруэл сууриар 35,347.0 сая төгрөгт хүрч, 291.6 сая төгрөгөөр давсан боловч, гүйцэтгэлээр 27,706.1 сая төгрөгийн орлого төвлөрч 7,349.3 сая төгрөгөөр тасарсан нь, санхүүгийн жил, хичээлийн жилийн зөрүүнээс үүссэн сургалтын төлбөрийн авлага барагдаагүйтэй холбоотой байна.

Тайлант онд урсгал зардалд 31,900.4 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 17,818.4 сая төгрөгийг, нийт 49,718.8 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,964.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 65.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 35,055.4 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 12,633.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Тайлант онд урсгал зардалд 31,900.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, гүйцэтгэлээр 30,982.0 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 2.9 хувь буюу 918.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 17,818.4 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас, 12,378.9 сая төгрөгийг зарцуулж төлөвлөгөөг 30.5 хувь буюу 5,439.5 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 23 эрсдэл тодорхойлж нийт 23 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 92.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Тайлант онд гарсан дараах анхаарал татахуйц чухал асуудлыг байгууллагын удирдлага үргэлжлүүлэн анхааралдаа авч, шийдвэрлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Капитал банк дампуурсантай холбоотойгоор тус банканд байршуулж байсан хадгаламжийн мөнгийг авах нэхэмжлэл үүсгэсэн. Банкнаас ирүүлсэн албан бичгээр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 4,087.3 сая төгрөгийн нэхэмжлэлийн шаардлага нь Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8 дахь хэсэгт хамаарч байгаа тул өмнөх дараалалд хамаарах 21 иргэн, 13 байгууллагын нийт 187,200.0 сая төгрөгийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар барагдуулах хуулийн зохицуулалттай байна гэжээ.

ТӨБЗГ-ын 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн албан даалгавраар шинэ цогцолборын А, Б блокийн барилга угсралтын ажил гүйцэтгэсэн 6 компанийг гэрээний үүргээ зөрчсөн гэж 10 хувийн алданги тооцоноос 2 компаниас нийт 117.9 сая төгрөгийн авлагатай, 4 компанид өгөх нийт 59.6 сая төгрөгийн өглөгтэй болсон. Эдгээр компани уг тооцоог хүлээн зөвшөөрөхгүй шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Дээрх 2 асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 140 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 128.7 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосноос 22.8 сая төгрөгийг барагдуулсан, 15,602.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 8 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Нийт 49.3 сая төгрөгийн түрээсийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Үүнээс 9 түрээслэгчийн нийт 30.4 сая төгрөгийн түрээсийн авлага нь 2018 онд үүссэн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Авлагыг барагдуулаагүй байх, найдваргүй авлага үүсэх;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Түрээсийн орлого, авлагыг сар бүр үүсгэж, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авах, тооцоо нийлж байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **3.2.1. Илрүүлэлт:**

Нүүр ам судлалын сургууль нь 2019 оны 12 дугаар сард 2 удаагийн шилжүүлгээр Оюу дент ХХК-аас 41.3 сая төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн багаж хэрэгсэл худалдан авахдаа харьцуулалтын арга ашиглаагүй байна. Энэ нь ТБОНӨБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг зөрчиж байна.

**3.2.2. Эрсдэл:**

ТБОНӨБАҮХАТ хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

**3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Худалдан авах ажиллагааны хууль, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

**3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас өгсөн албан шаардлагын дагуу нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл яаралтай худалдан авах шаардлагатай болсон ба тухайн үед өмнө нь зарласан тендерийн дагуу бараа нийлүүлж байсан Оюу дент ХХК-г шууд сонгож бараа авсан болно. Хойшид хэрэгжүүлж ажиллана.

**3.3 Зардлын данстай холбоотой асуудал**

**3.2.1. Илрүүлэлт:**

Нийгмийн эрүүл мэндийн сургууль 3 сард 1.0 сая төгрөгийн сургалтын хөлсийг сургалт явуулсан багшид олгохдоо хандив гэсэн гүйлгээний утгатай шилжүүлэн, 0.2 сая төгрөгийн НДШ, 0.1 сая төгрөгийн ХХОАТ, бүгд 0.3 сая төгрөг суутган тооцож тайлагнаагүй байна. Төсөл, эрдэм шинжилгээний Уламжлалт анагаах ухааны чихрийн шижин төслөөс 6 хүнд 4-9 сарын цалин 4.6 сая төгрөгийн цалин олгохдоо 1.1 сая төгрөгийн НДШ, 0.3 сая төгрөгийн ХХОАТ, бүгд 1.4 сая төгрөг суутган тооцож тайлагнаагүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**3.2.2. Эрсдэл:**

Цалин хөлсийг холбогдох заавар, журмын дагуу тооцож олгоогүй байх, шимтгэл татварыг хуулийн дагуу суутган тооцоогүй байх;

**3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Цалин хөлсийг холбогдох заавар, журмын дагуу тооцож олгох, НДШ, ХХОАТ-ын холбогдох хууль, журмын дагуу суутган тооцож төсөвт төвлөрүүлж байх.

**3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Хүлээн зөвшөөрч байна. Хойшид хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>34,024,205,769.31</u></b>	<b><u>28,159,409,123.34</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	28,590,532,029.88	13,266,736,615.13
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	15,399,237,462.55	11,087,555,122.87
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	13,831,057,917.77	10,775,351,875.89
31213	Арилжааны банк дахь харилцах	13,831,057,917.77	10,775,351,875.89
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	1,568,179,544.78	312,203,246.98
31223	Арилжааны банк дахь харилцах	1,568,179,544.78	312,203,246.98
31500	Хадгаламж	13,191,294,567.33	2,179,181,492.26
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,439,719,584.43	14,142,770,710.81
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,365,644.00	17,133,912.96
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,199,805,083.80	8,232,128,131.03
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,527,639,664.77	1,527,639,664.77
33400	Зээлийн хүүгийн авлага	1,485,542,640.05	28,986,301.37
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	222,366,551.81	4,336,882,700.68
3351	Байгууллагаас авах авлага	196,011,783.16	4,314,818,353.03
3352	Хувь хүмүүсээс авах авлага	26,354,768.65	22,064,347.65
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	301,598,164.00	10,550,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	301,598,164.00	10,550,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	692,355,991.00	739,351,797.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	241,253,332.70	226,713,099.98
35110	Тусгай зориулалттай материал	193,455,927.76	212,684,673.36
35130	Эм боох материал	47,797,404.94	14,028,426.62
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	81,766,115.63	81,766,115.63
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	366,391,142.67	411,347,581.79
35410	Бичиг хэргийн материал	36,958,491.33	44,483,978.67
35420	Аж ахуйн материал	213,617,620.38	233,870,956.68
35430	Сэлбэг хэрэгсэл	211,100.00	-
35440	Түлш, шатах тослох материал	1,227,361.00	6,341,000.00
35450	Барилгын засварын материал	10,773,335.19	20,028,719.11
35460	Хүнсний материал	776,298.00	-
35470	Бусад хангамжийн материал	102,826,936.77	106,622,927.33
35600	Мал амьтад	2,945,400.00	19,525,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>71,920,461,617.68</u></b>	<b><u>81,350,213,886.70</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	71,920,461,617.68	81,350,213,886.70
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	51,535,565,673.42	60,749,407,749.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	27,066,221,193.92	27,683,881,199.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	(204,052,472.85)	(1,179,486,420.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	634,838,542.29	786,708,542.29
39204	Хуримтлагдсан элэгдэл	(372,495,477.20)	(441,716,429.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,544,516,958.37	17,102,015,713.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,799,538,106.92)	(12,999,033,717.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,507,606,673.54	5,230,694,632.54

39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,225,538,674.42)	(2,741,745,061.52)
39209	Зам, гүүрийн байгууламж	226,383,955.88	226,383,955.88
39210	Хуримтлагдсан элэгдэл	(11,984,241.00)	(32,968,997.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	358,368,436.73	420,969,436.73
39215	Хуримтлагдсан элэгдэл	(211,791,059.13)	(298,149,952.16)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	16,185,280,322.11	26,092,412,109.98
39217	Ном	837,749,622.10	899,442,736.10
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>20,384,895,944.26</b>	<b>20,600,806,137.58</b>
39301	Программ хангамж	148,737,917.00	383,272,177.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(90,176,550.46)	(108,133,950.42)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,330,766,800.00	20,330,766,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4,432,222.28)	(5,098,889.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>105,944,667,386.99</u></b>	<b><u>109,509,623,010.04</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>6,005,224,227.67</u></b>	<b><u>5,104,697,762.21</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,005,224,227.67</b>	<b>5,104,697,762.21</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,237,556,450.02</b>	<b>159,013,893.10</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,052,609.20	7,087,111.35
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	161,729,749.00	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,068,774,091.82</b>	<b>151,926,781.75</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,040,443,871.82	143,197,740.39
